СЭЛЭНГЭ
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД АЙМГИЙН ЗАСАГ АРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

## 2024 он

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, СЭЛЭНГЭАЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ-2024**

| № | Гэрээний заалт | Агуулга | Зарцуулсан хөрөнгө | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ |
|---|---|---|---|---|---|---|
| ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ | | | | | | |
| 1 | 3.1 | Хэрэгжүүлэгч нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны | | Тогтоол, тушаал, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилт | Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна. | "Цахим эрүүл мэнд" төслийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг "E-Health" программыг нэвтрүүлснээр амбулаторийн цахим бүртгэл, үзлэгийн кабинетууд болон тасгууд, лаборатори хоорондоо цахимаар холбогдон оношилгоо, үзлэгийн дугаар авах, шинжилгээнд илгээх, хариу авах, яаралтай тусламжийг эрэмбэлэн цаг алдалгүй оношилгоо шинжилгээнд илгээх, хариуг хүргэх ажлууд шуурхай болсон. 2023 оны байдлаар 316506 иргэн цаг бүртгүүлэн, 238193 иргэнд үйлчилгээ үзүүлэн, и-монголиагаас 606 иргэн, утсаар 3833 хүн цаг аван үйлчилгээнд хамрагдсан байна. **Биелэлт 100%** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, эрүүл мэндийн чиглэлээрх арга хэмжээний төлөвлөгөө зэрэгт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэн гэрээний үр дүнг Захиалагчийн өмнө хариуцна. | | | | |
| 2 | 3.2 | Улс орон даяар зохион байгуулж байгаа “ Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг”-т өөрийн харъяа нутаг дэвсгэрийн хүн амыг насны бүлгээр хамруулж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт ажил олгогёид болон салыар дундын хамтын ажиллагаг өрнүүлж хамрагдалтыг 70- | **Улсын төсөв** | Тогтоол, тушаал, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилт | Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/229 захирамжийн дагуу “Хүн амын нас хүйс, эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээ”-ний 6 багц үзлэгийг анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагуудад аймгийн хэмжээний 107889 иргэнд зохион байгуулахаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт тус тус Эрүүл мэндийг дэмжих төвийг 2022 онд байгуулсан.<br>Сэлэнгэ аймгийн хэмжээнд хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | аас доошгүй хувьд хүргэнэ | | | | 44795 иргэн хамрагдсан бөгөөд хамралтын хувь 41.9 хувь байна.<br>Үүнд:<br>0-17 насны хүүхдийн эрт илрүүлэгт 30402 буюу 80.9 хувь<br>18-аас дээш насны насанд хүрэгчийн эрт илрүүлгийн багцад 14393 буюу 20,8 хувь тус тус хамрагдсан байна.<br>**Биелэлт 100%** |
| 3 | 3.3. | Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 2016 дугаар тогтоолын дагуу харъяалах Эрүүл мэндийн байгууллагуудын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллана. | **Улсын төсөв** | Хамтран ажилласан байгууллагын тоо | Салбар дундын хамтын ажиллагаа нэмэгдэнэ. | Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дунд хугацааны стратегийг 6 чиглэлийн 218 зүйл заалтыг дэвшүүлэн хэрэгжүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>**биелэлт 80%** |
| 4 | 3.4. | Харъялах нутаг | **Улсын** | Хамтран | Албан хаагчид | Эрүүлийн мэндийн тухай хуулийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтанг хууль журмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана. | **төсөв** | ажилласан байгууллагын тоо | тогтвор суурьшилтай ажиллана. | 11.3 дахь заалтын дагуу Хушаат сумын эрүүл мэндийн төв, Хэрх тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нар орон нутгийн сонгуульд нэр дэвших, Сант сумын эрүүл мэндийн төв, Орхон сумын эрүүл мэндийн төв, Орхонтуул сумын эрүүл мэндийн төв, Рашаант тосгоны эрүүл мэндийн төв, Цагааннуур сумын эрүүл мэндийн төв, Түнхэл тосгоны эрүүл мэндийн төв нийт 8 эрүүл мэндийн төвийн даргыг харъяалах сумдын Засаг дарга нараас ирсэн хүсэлтийн дагуу зөвшилцсөн байна. **Биелэлт 100%** |
| 5 | 3.5 | Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18, 21.1.16 дахь заалтын дагуу төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, ашиглалт засвар үйлчилгээний ажлын санхүүжилтийг | **Улсын төсвийн хөрөнгө оруулалт 6,5 тэрбум төгрөг** | Хууль, тогтоол, тушаал, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилт | Хууль, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна. | Улсын төсвийн 3,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэгт "Нэгдсэн эмнэлгийн цэвэр, бохир усны шугам хоолой, халаалтын шугам, агааржуулалтын хоолойг шинэчлэх" засварын хийгдэхээр зураг төсөв хийгдэж төлөвлөгдсөн байсан. Уг засварын ажлын 2,8 тэрбум төгрөг нь 2023 оны төсөвт тусгагдсан бөгөөд уг засварын ажил 2023 он, 2024 онуудад он дамжин хийгдсэн. Орон нутгийн 965,400,000 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бүрэн шийдвэрлэж ажиллана | | | | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасаг, мэдрэлийн тасаг, хүүхдийн тасаг, уламжлалтын тасгийн их засварын ажил хийгдэж, ажлын явц 25 хувьтай байна.<br><br>Улсын төсвийн 608,500,000 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Жавхлант сумын Эрүүл мэндийн төвийн 5 ортой эмнэлгийн өргөтгөлийг барьж, улсын комисс хүлээн авч бүрэн ашиглалтад оруулсан.<br><br>Орон нутгийн 55 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхонтуул сумын эрүүл мэндийн төв, Рашаант тосгоны эрүүл мэндийн төвүүдийн барилгын дээврийн их засварын ажил хийгдэж бүрэн ашиглалтад орсон байна.<br>Орон нутгийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Сүхбаатар сумын 5-р багт Өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилга барих ажил, Орон нутгийн 173 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын 4-р багт өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих ажил, 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хушаат сумын эрүүл мэндийн төвд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмийн сангийн барилгын ажил хийгдэх бөгөөд сонгон шалгаруулалтын шатандаа явж байна. Цагааннуур сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг "Девсофт" ХХК нь гүйцэтгэгчээр шалгарч ашиглалтад бүрэн оруулсан байна.<br>Эрүүл мэндийн яаманд 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Бугант тосгонд 10 ортой эрүүл мэндийн төв, Мандал суманд 50 ортой хүүхдийн эмнэлэг, Алтанбулаг суманд 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга, Зүүнбүрэн суманд 10 ортой эрүүл мэндийн төвийн барилга, Сүхбаатар суманд Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгуудыг нэг маягийн зураг төсөл боловсруулахаар ажлын даалгавар хүргүүлэн ажилласан.<br>Сүхбаатар сумын өрхийн эрүүл мэндийн төвийн нэг маягийн загвараар барилгыг барьж эхэлсэн.<br>**Биелэлт 100%** |
| 6 | 3.6. | Эрүүл мэндийн байгууллагын барилгыг шинээр ашиглалтад оруулсан тохиолдолд хуучин барилгыг эрүүл мэндийн | **Улсын төсөв 608,500,000 сая төгрөг** | Тогтоол, тушаал, зөвлөмж, үүрэг даалгаврын Х эрэгжилт | Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж | Жавхлант сумын Эрүүл мэндийн төвийн 5 ортой эмнэлгийн өргөтгөлийг улсын төсвийн санхүүжилтээр 608,500,000 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар барьж, улсын комисс хүлээн авч бүрэн ашиглалтад оруулсан бөгөөд энэ нь эмнэлгийн өргөтгөлийн хэсэг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээнд ашиглахгүй | | | ажилласан байна. | болж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх амбулаторийн хэсгийн шүдний кабинет, сэргээн засах, лабораторийн хэсгийг шинээр ашиглалатад оруулсан. **Биелэлт 100%** |
| 7 | 3.7. | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн өөр, авлагыг барагдуулан шинээр өр үүсгэхгүй | **Улсын төсөв** | Тогтоол, тушаал, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилт | Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна | Эрүүл мэндийн салбар 2024 оны 12 сарын 31 байдлаар 2.8 тэрбум төгрөгийн өглөгтэй, Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,1 тэрбум төгрөгийн авлагатай. Биелэлт 80% |
| 8 | 3.8. | Орон нутагт эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд чанартай зохион байгуулна | **512 сая** | Тоног төхөөрөмжийн хангалт | Тоног төхөөрмжийн хангалт нэмэгдсэн байна | Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 142 дугаар тогтоолоор эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахаар 5 төсөл арга хэмжээний 512 сая төгрөгийг төсөвлөснөөс 3 төсөл арга хэмжээнд Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу орон нутгийн худалдан авах ажиллагааны газарт тендер зарлагдан 100%-ийн хэрэгжилттэй байна. **Биелэлт 100%** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9 | 3.9 | Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ядуу, эмзэг бүлгийн иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, их дээд сургууль_, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх энэ чиглэлээр орон нутгийн удирдлаг, иргэдтэй хамтран ажиллах эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулна. | **Улсын төсөв** | Сургалтыг тасралтгүй зохион байгуулах | | Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ И-БАРИМТ аппликэйшнээр хэрхэн шалгах төлөх талаарх мэдээллийг хэлтсийн нүүр номын хуудсаар дамжуулан хүргэж байна. Мөн хэлтэс дээр биечлэн ирж болон утсаар зөвлөгөө авсан 156 иргэнд шимтгэлээ И-БАРИМТ аппликэйшнээр хэрхэн шалгах төлөх талаарх мэдээллийг хүргэж газар дээр нь шимтгэлийг төлүүлсэн байна. Гэрээт эрүүл мэндийн байгууллагууд мөн аппликэйшн ашиглаж шимтгэл төлөх тал дээр иргэд даатгуулагчдад зөвлөгөө өгч ажиллаж байна. Нээлттэй хаалганы өдрийг нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран зохион байгуулж эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудлаар иргэдийн сонирхсон асуултанд хариулж 52 иргэнд зөвлөгөө өгсөн.<br>Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлын хүрээнд сумын засаг даргын тамгын газрын баг хамт олны хамт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1,6-р багийн ахмадын өдөрлөгт оролцон нийт 40 гаруй иргэн, стандарт хэмжил зүйн хэлтсийн 15 ажилтанд эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ, шимтгэл төлөлтийн талаар мэдээлэл өгч ажилласан. 1180 ширхэг хэвлэмэл хуудсыг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаар тарааж иргэд даатгуулагчдад сурталчилгааны хэвлэмэл хуудсыг ашиглаж мэдээ мэдээлэл өгч ажилласан.<br>**Биелэлт -92,1%** |
| 3.10 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр | | | | | | |
| | 3.10.1 | Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн ялан гуяа сумын эрүүл мэндийн төвд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгэг өргөжүүлэн амны хөндийн үзлэг | Улсын төсөв | Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүүхдийн тоо, эрүүлжүүлэлтийн хувь | Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол сайжирсан байна. | 1.Иргэдэд хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилгоор Алтанбулаг, Баянгол, Цагааннуур, Шаамар сум, Хэрх, Түнхэл тосгоны эрүүл мэндийн төвүүдэд шүдний кабинетыг байгуулан ажиллаж байна.<br>2.Мандал сумын 9-12 насны 80 гаруй хүүхдүүдийн шүдийг 100% эрүүлжүүлж, сургуулийн эмч нар хүүхдүүдээ бэлтгэсний үндсэн дээр Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.<br>3.Сүхбаатар сумын ЗДТГ-тай хамтран “Эрүүл ирээдүй” уриан дор Амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр цэцэрлэгийн эрхлэгч, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | оношлогоо, эмчилгээний явуулын баг ажилуулна. | | | | эмч нарын нийт 18, эрүүл мэндийн байгууллагын 18, нийтдээ 36 сургагч багш бэлтгэж, багш нар 9 цэцэрлэгийн 600 гаруй эцэг эх, асран хамгаалагч нарт Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйн зөвлөгөө, сүүн шүдний арчилгаа зэрэг мэдээлэл өгч шүд угаалтын макет, үзүүлэнгээр хангаж ажиллалаа.<br>4. “Эрүүл насжилт” сургалтын агуулгад Ахмад настны амны хөндийн эрүүл мэнд, хиймэл шүдний талаарх зөвлөгөө мэдээллийг тусган 300 гаруй настанд мэдээлэл өгч ажиллав.<br>5. Хилийн цэргийн 0101-р ангийн албан хаагчдад эрүүл шүдний талаарх сургалтыг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.<br>6. Дээрх амны хөндийн эрүүл мэндийн нөлөөллийн ажил, мэдээ, мэдээллийг цахим орчинд Эрүүл мэндийн газрын албан ёсны хуудсаар дамжуулан сурталчилж 10589 гаруй үзэлт, 1802 гаруй таалагдсан сэтгэгдэл авсан байна.<br>Үр дүн:<br>1. Шүд цоорох өвчний хүндрэлээс сэргийлж цаг алдалгүй эмчилгээнд хамрагдаж байна.<br>2. Хүүхдүүдийн амны эрүүл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн боловсрол нэмэгдэж байна.<br>**Биелэлт 100%** |
| | 3.10.2 | Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" арга хэмжээг орон нутгийн түвшинд бусад салбар нэгжийн оролцоог хангаан зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | Улсын төсөв | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх | Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн байна | Дэлхийн Зөн Монгол ОУБ, Сэлэнгэ аймгийн БШУГ-тай хамтран "Өсвөр насныхны эрүүл мэнд ба бидний оролцоо" сэдвээр Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-6-р сургууль, Спорт сургууль, ХААИС-ийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехникийн коллежийн 54 сурагчдыг үе тэнгийнхнийгээ сургах сурагч багшаар бэлтгэлээ.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхдийн зөвлөл, Эрүүл мэндийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, "Хамтдаа" ТББ-ууд хамтран "Бэлгийн цогц боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хорт зуршлаас татгалзая" сэдвийн хүрээнд Сүхбаатар, Мандал сум, Түнхэл, Хэрх тосгоны Е...Б...С....-ын сурагч, багш нарыг үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалтад нийт 64 хүнийг бэлтгэн сертификаттай болгосон. Өсвөрийн сургагч багшаар бэлтгэгдсэн багш сурагчид өөрсдийн сургуулийн үе тэнгийн сурагчиддаа өсвөр насны хүүхдийн бэлгийн цогц боловсрол, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөхөн үржихүйн эрүүл мэнд, зөв хооллолт, өсвөр үеийг цахим халдлага, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, мансуурах, стресс менежментийн талаар нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 1000 гаруй хүүхдүүдийг хамруулсан.<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Онцгой байдлын газрын ажилтан албан хаагч нарын нийт 100 гаруй хүнд нөхөн үржихүй эрүүл мэнд, бэлгийн замаар дамжих халдварын талаар танхимын сургалтыг зохион байгуулсан. Мөн бусад ахмад настан, бусад албан байгууллагын албан хаагч, иргэдэд тухайн чиглэлийн дагуу нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажил үйлчилгээг нийт 2500 гаруй хүнд хүргэсэн<br>Аймгийн Засаг даргын Тамгийн газрын Цэргийн штабтай хамтран хугацаат цэргийн татлагын 1 дүгээр ээлжинд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдаж байгаа нийт 782 цэргийн насны залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замаар дамжих халдвар, хорт зуршил, электрон тамхины сөрөг тал сэдвүүдээр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл сургалтыг зохион байгуулж ажилласан.<br>Сүхбаатар сумын Засаг даргын Тамгийн газартай хамтран "Алсын хараа - 2050" урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил"-ийн хүрээнд "Эрүүл насжилт" сургагч багш бэлтгэх сургалт нийт 293 ахмадад зохион байгуулж, гэрийн асаргаа сувилгаа шаардлагатай 80 ахмадуудад хүрч үйлчлэн ажиллаа.<br>Чихрийн шижин өвчтэй хүмүүсийн амьдралын хэв маягыг судлан, шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг мэдээ, мэдээллээр хангах, ЧШӨ-ний талаархи мэдлэг олгох, сэргийлж болох эрдлээс ард иргэдийг урьдчилан сэргийлэх зорилготой хагас өдрийн танхимын сургалтыг Эрүүл мэндийн газрын даргын А/38 дугаар тушаалын дагуу Шаамар, Цагааннуур суманд 2024 оны 6,8 дугаар сард зохион байгууллаа.<br>Шаамар, Цагааннуур суманд амьдардаг ЧШӨ-тэй болон эрсдэл бүхий 110 гаруй иргэнд халдварт бус өвчний чиглэлээр тулгамдаж буй асуудал, эрүүл мэндийн боловсрол олгож, нийгэм – сэтгэл зүйн асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгч, эрүүл зохистой хоолоор |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилж ажиллалаа.<br>Нийт ард иргэдэд сургалтын талаархи мэдээлэл өгч, өвчнөөс урьдчилан сэргийлэх сурталчилгааг өрнүүлж Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд байршуулан ажилласнаар 1 өдрийн дотор 1900 хүн үзэж, 60 таалагдсан сэтгэгдэл, 31 удаа хуваалцсан үр дүнтэй байна.<br>Үр дүн:<br>Иргэдийн халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага сайжирсан байна<br>**Биелэлт 100%** |
| | 3.10.3 | Хэрэгжилтийн хугацаа дуусч буй дараах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлнэ.<br>Үүнд:<br>Эрүүл идэвхтэй амьдрал;<br>Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл<br>Хавдрын эсрэг;<br>Харшлаас | **Улсын төсөв** | Аймгийн хэмжээнд дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж 40 хүртэл хувийг зохион байгуулсан байна. | -Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшиж "Эрүүл идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл чийрэг эр хүн, | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшиж "("Эрүүл идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл чийрэг эр хүн", "Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх", Орчны эрүүл мэнд болон бусад)- арга хэмжээнүүдийн хүрээнд 272 арга хэмжээ төлөвлөснөөс энэ жил 252 арга хэмжээг 92,6%-тай хэрэгжүүлсэн байна.<br>**Биелэлт 92,6%** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх<br>Эрүүл чийрэг эр хүн;<br>Элэг бүтэн Монгол;<br>Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх;<br>Орчны эрүүл мэнд | | | Халдварт өвчинтэй тэмцэх, Орчны эрүүл мэнд арга хэмжээнүүд зохион байгуулагдсан байна | |
| | 3.10.4 | Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өргөнөөр татан оролцуулах арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулна. | Улсын төсөв | Уулзалт, хэлэлцүүлэг, сургалт, арга хэмжээ зохион байгуулсан тоо | Арга хэмжээ зохион байгуулагдаж, хамтын ажиллагааг хангасан байна. | “Эрүүл зөв амьдрал” жижиг төвүүд ажиллуулах боломжийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор хангах хүрээнд 2021-2024 онуудад Мандал, Сүхбаатар, Баянгол суманд “Эгшиглэнт аяз”, “Сэлэнгэд амьдрах сайхан” зэрэг нийтийн бүжгийн 4 клуб, Сүхбаатар, Мандал, Сайхан, Баянгол, Цагааннуур сумдад 8 фитнесс клуб, иогийн 4 клуб, спорт болон цэнгээнт бүжгийн 4 клуб, спиннингийн 5 клуб тус тус үйл ажиллагаа нь тогтмол явагдаж байна.<br>Нийт сумдад сумын Соёлын төв болон ахмадын хороог түшиглэн Нийтийн болон шугаман бүжиг, хийн дасгалын хичээлүүдийг иргэдэд зааж, хөдөлгөөн эрүүл мэндийг сурталчилж байна.<br>Мөн аймгийн хэмжээнд дугуйн клуб 2, алхалтын 1, дартс болон |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | теннисний спортын клубууд ажиллахаас гадна сагсан бөмбөгийн залуучуудын нэгдэл улирал бүр тэмцээн, уралдааныг зохион байгуулж хэвшсэн.<br>Эрүүл хооллолтын чиглэлээр “Манду Сэлэнгэ” эрүүл хооллолтын төв тогтмол үйл ажиллагаа явуулахаас гадна бүх шатны Эрүүл мэндийн байгууллагууд жил бүр “Давсны хэрэглээг бууруулъя аян”, “Чихрийн шижин өвчнөөс сэргийлье танхимын сургалт”, “Эрүүл зохистой хооллолтын талаарх цахим зөвлөгөө”, “Настны эрүүл мэнд – зохистой хооллолт” зэрэг ажлуудыг өрнүүлэн ард иргэдэд эрүүл хүнс, зохистой хооллолтыг сурталчлан ажиллаж байна.<br>НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр тохижуулсан "Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох кабинет"-д Шаамар, Алтанбулаг, Сүхбаатар сумын ЕБС-ийн 300 гаруй сурагч хуваарийн дагуу хүрэлцэн ирж “Эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн, эмнэлгийн яаралтай тусламж, сэтгэл гутралаас сэргийлэх, насны онцлог, бэлгийн боловсрол” зэрэг сэдвээр үе |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэнгийн сургагчаар бэлтгэгдлээ. **Биелэлт 100%** |
| | 3.10.5 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хүний нөөцийг орон нутагтаа бүрдүүлэх, энэ чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах, шаардлагатай мэргэжилтнийг улсын төсөвийн санхүүжилт (төрийн сан)-аар сургалтад хамруулан гэрээ байгуулж ажиллана. | **Улсын төсөв** | | | 2024 онд дурангийн сувилахуй, чихрийн шижингийн сувилахуй, эрчимт эмчилгээний сувилагч тусгай мэргэжилтний төрөлжсөн мэргэшил олгох сургалтад нийт 3 сувилагч, тусгай мэргэжилтэн, дотор судлал, яаралтай тусламж судлалын үндсэн мэргэшил олгох сургалтад 3 их эмч, төрийн сангийн санхүүжилтээр үндсэн мэргэшил олгох сургалтад нийт 6 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төрийн сангийн санхүүжилтээр сургаж байна. **Биелэлт 100%** |
| | 3.10.6 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой | | | | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн "Цар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байдал, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн Эрүүл мэндийн байгууллагын тогтвортой байдлын төлөвлөгөөг орон нутгийн түвшинд батлан хэрэгжүүлнэ. | | | | тахлын дараах эрүүл мэндийн салбарын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/ батлах тухай" А/180 тоот тушаалын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2024 оны 8 дугаар сард "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн Эрүүл мэндийн байгууллагын тогтвортой байдлын төлөвлөгөө"-г батлах хэлэлцүүлэг, сургалтад Хөвсгөл аймагт Төвийн бүсийн аймгууд буюу Дархан-Уул, Хөвсгөл, Орхон, Булган, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, эрүүл мэндийн газар, онцгой байдал, аймгийн нэгдсэн эмнэлгийн холбогдох удирдлага мэргэжилтнүүд хамрагдан холбогдох саналаа өгч ажилласан байна.<br>Биелэлт 100% |
| | 3.10.7 | Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг | Улсын төсөв | Төр болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, илрүүлэг үзлэгийг нэмэгдүүлэх | Төр болон төрийн бус байгууллагын албан хаагч, ажилтан, зорилтод бүлгийн иргэдийг БЗДХ илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулж, | Аймгийн хэмжээнд сүрьеэ өвчний шинэ тохиолдол 2024 оны 11-р сарын байдлаар 86 буюу 10000 хүн амд 7,8 байна. Энэ нь мөн оны мөн үеэс 0,3 промиллоор өссөн үзүүлэлттэй байна. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлах тухай" А/30, Эрүүл мэндийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ. | | | илэрсэн өвчлөлийг эмчилгээ хяналтанд авч эрүүлжүүлсэн байна. | газрын даргын 2022 оны А/17, А/20, А/24, А/29 тоот тушаалуудын хэрэгжилтийг хангах зорилгоор "Уушгины эмгэг илрүүлэх хиймэл оюун ухаанд суурилсан үзлэг"-ийг 12 сум, тосгонд зохион байгуулсан. Тус үзлэгт нийт 4054 эрсдэлт бүлэг болон хавьтлын иргэд хамрагдаж, рентген зурагт өөрчлөлттэй 350 хүн илэрч, 130 хүнээс цэрний шинжилгээ авч сүрьеэгийн шинэ тохиолдол 3-ийг илрүүлээд байна. .Аймгийн ИТХ-ын 2023 оны 120 дугаар тогтоол "Сүрьеэгүй Сэлэнгэ -2" арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд орон нутгийн удирдлага, багийн дарга, нийгмийн ажилтан, асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд "Сүрьеэ өвчин ба нийгмийн эрүүл мэнд" сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтанд Сайхан сумын Засаг даргын тамгын газрын 8, Орхон сумын Засаг даргын тамгын газрын 9, Сант сумын Засаг даргын тамгын газрын 9, Баруунбүрэн сумын Засаг даргын тамгын газрын 19, Номгон тосгоны Эрүүл мэндийн төвийн 10, Бугант тосгоны Захирагчийн албаны 8, Ерөө сумын Засаг даргын тамгын газрын 15, Жавхлант сумын Засаг даргын тамгын газрын 14 мэргэжилтэн, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтан нар буюу нийт 92 албан хаагч хамрагдсан байна.<br>2024 оны 11 дүгээр сарын байдлаар 10,000 хүн амд трихомониаз 7.1, заг хүйтэн 3.4, тэмбүү 4.2 промилл байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал заг хүйтэн 0.6, трихомониаз 1.3 промил, тэмбүү 1.3 промиллоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.<br>Бэлгийн замаар дамжих халдварын кабинетын нийт үзлэгийн 64,4% урьдчилсан сэргийлэх эрт илрүүлэг, эмчилгээний хяналт 55% байна.<br>БЗДХ-ын кабинетын үзлэг, шинжилгээнд 49-р долоо хоногийн байдлаар үзлэг – 7527, ийлдэс судлалын шинжилгээ – 7887 байгаагаас тэмбүү – 64, заг хүйтэн – 44, трихомониаз – 86 тус тус бүртгэгдсэн байна.<br>Хүн амын нас хүйс, эрсдэлт суурилсан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоонд 2024 оны 11 сарын байдлаар нийт 7243 хүн ХДХВ/ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамрагдсан байна.<br>НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөр, Боловсрол Шинжлэх Ухааны Газар, Хүүхэд, гэр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран өсвөр насны хүүхдийн чиглэсэн бэлгийн цогц боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдвээр шат дараатай сургалт, нөлөөллийн ажлыг 9 удаа зохион байгуулж 1240 гаруй хүүхэд хамрагдсан.<br>Бэлгийн Замаар дамжих халдварын оношилгооны чадавхыг сайжруулах хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лабораторид 7 болон 14 вирусийн шалтгаанаар үүсгэгддэг бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг оношлох бэлтгэл ажлыг хийж байна.<br>Шээс бэлгийн замаар дамжих халдварыг 14 үүсгэгчээр илрүүлэх ПГУ-ын шинжилгээ, бэлгийн замаар дамжих үндсэн 7 халдварын шинжилгээг тус, тус 100 хүнд хийсэн.<br>Шээс бэлгийн замаар дамжих халдварыг 7 үүсгэгчээр илрүүлэх ПГУ-ын шинжилгээг 210 хүнд хийсэн.<br>Бэлгийн замаар дамжих халдварын 7 болон 14 халдвар илрүүлэх шинжилгээ өгсөн иргэдийн 74,5% нь эерэг гарсан бөгөөд үүнээс хоёр буюу хавсарсан халдвартай хүн 30%, гурав төрлийн үүсгэгч илэрсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүн 24,3%, дөрвөн төрлийн үүсгэгч илэрсэн хүн 5,8%, таван төрлийн үүсгэгч илэрсэн хүн 3,1% байна. Шинжилгээнд өөрчлөлттэй илэрсэн иргэдийг эмчилгээ хяналтад авч эрүүлжүүлж байна.<br>Үр дүн: Иргэд, албан хаагч, ажилтны бэлгийн замаар дамжих халдварын, мэдлэг хандлага сайжирснаар, тус өвчний эсрэг оношилгоо, шинжилгээний хамралт нэмэгдэж, эрт үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг авч хяналтанд хамрагдсан байна.<br>**Биелэлт 100%** |
| | 3.10.8 | Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт | Улсын төсөв | Салбар дундын хамтын ажиллагааг хангах | Салбар дундын хамтын ажиллагаа сайжирсан байна. | Дэлхийн Зөн Монгол ОУБ, Сэлэнгэ аймгийн БШУГ-тай хамтран "Өсвөр насныхны эрүүл мэнд ба бидний оролцоо" сэдвээр Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-6-р сургууль, Спорт сургууль, ХААИС-ийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехникийн коллежийн 54 сурагчдыг үе тэнгийнхнийгээ сургах сурагч багшаар бэлтгэлээ.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхдийн зөвлөл, Эрүүл мэндийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, "Хамтдаа" ТББ-ууд хамтран |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | | | "Бэлгийн цогц боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хорт зуршлаас татгалзая" сэдвийн хүрээнд Сүхбаатар, Мандал сум, Түнхэл, Хэрх тосгоны ЕБС-ын сурагч, багш нарыг үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалтад нийт 64 хүнийг бэлтгэн сертификаттай болгосон. Өсвөрийн сургагч багшаар бэлтгэгдсэн багш сурагчид өөрсдийн сургуулийн үе тэнгийн сурагчдадаа өсвөр насны хүүхдийн бэлгийн цогц боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, зөв хооллолт, өсвөр үеийг цахим халдлага, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, мансуурах, стресс менежментийн талаар нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 1000 гаруй хүүхдүүдийг хамруулсан.<br>Аймгийн хэмжээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд өөрийн цахим хуудас, фейсбүүк хуудас, Сэлэнгэ Түмэн эрүүл мэндийн мэдээ мэдээлэл түгээгч хуудсаар сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа, видео контент, инфографикийг иргэд, төрийн албан хаагч нарт цахимаар хүргэн ажиллаж байна.<br>Сүхбаатар сумын иргэдийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлөгчдийн хурлын “Тайван - Сүхбаатар” дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах “Архигүй хамт олон” болзолт уралдааныг Сүхбаатар сумын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын бүх ажилтан, албан хаагч нарт 2023.11.09-ний өдрөөс 2024.01.26-ний хооронд зохион байгуулж байна. Тус болзолт уралдаан туг аялах хуваарийн дагуу төрийн байгууллага, боловсрол, соёл урлагийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагууд хамт олноороо ажлын 5 хоногийн хугацаанд архины зохисгүй хэрэглээ, сөрөг үр дагавар түүний эсрэг ажил арга хэмжээг зохион байгуулах, өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.<br>Нэгдсэн эмнэлэг нь Хүүхэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн оюун ухааны чадамж тодорхойлох 200 гаруй асуумж бүхий IQ оношилгооны сорилд 30 хүүхдийг хамруулсан. Мөн Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгтэйгээр “Монгол Танака Бине” сорил авагчаар сэтгэцийн эмч бэлтгэгдсэн ба цаашид гэр бүлийн дэмжлэг шаардлагатай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхэд, өсвөр үеийнхэнд үнэлгээ хийгдэх юм.<br>Аймгийн Цагдаагийн газар, Боловсролын газар хамтран "Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе" аяныг Бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудад өрнүүлэн ажиллаж байна.<br>**Биелэлт 100%** |
| | 3.10.9 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг мэндийн байгууллагад бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авах эрхийг бүрдүүлж ажиллана. | Улсын төсөв | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна. | Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарын 100 гаруй төр болон хувийн хэвшлийн эрүүл хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэн амбулаториор үйлчлүүлэхэд налуу зам, тэргэнцэр, дуугүй хөтчийг хананд барьж явах бариулыг шинээр хийсэн. Хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд толгой угаах цомог, хоол идэх цомог, 00 өрөө, дуут хонх зэргийг шинээр байгуулан, гэрээр эргэх иж бүрэн цомгийн бүрдэлтэй болсон байна. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламжийг боловсронгуй болгох зорилгоор угтах, лавлах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний удирдамжийг боловсруулан хүргүүлсэн ба хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Аймгийн эрүүл мэндийн газрын даргын баталсан эрүүл мэндийн байгууллагын ариун цэврийн байгууламжийг шинэчлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөг бий болгох удирдамжийг бүх шатанд хүргүүлэн ажиллаж байна.<br>Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусламж үйлчилгээ авах нөхцөл 20% хүртэл нэмэгдсэн байна.<br>Үр дүн:<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхөцлийг бүрдүүлэн ажилласнаар, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.<br>**Биелэлт 100%** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3.10.10 | Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаан эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжгай болоход дэмжлэг үзүүлж, 1-2 сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн байгуулна. | Улсын төсөв | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх | Иргэний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна. | Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар салбарын хэмжээнд “Нүхэн жорлонг халах аян” өрнүүлж, анхан болон лавлагаа шатны бүх эмнэлгүүд орчин үеийн шаардлага хангасан ариун цэврийн боловсон байгууламжтай болж чадсан. **Биелэлт 100%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар | | | | | |
| | 3.11.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” МЫ8 7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрт хэвшүүлэх, сурталчлах арга хэмжээ хэрэгжүүлэн хэрэгжилтэд хяналттавьж ажиллана. | | | “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих MNS 7014:2023 стандарт”-ын сургалтыг танилцуулах, сурталчлах, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор мэдлэг олгох сургалтыг Эрүүл мэндийн салбарын 17 сум 6 тосгоны чанарын багийн гишүүд болон аймгийн нэгдсэн эмнэлгийн чанарын баг, тасгийн эрхлэгч, амбулаторийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулан хяналт тавьж тайланг хугацаанд нь авч стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. **Биелэлт 100%** |
| | 3.11.2 | Алслагдсан бүс нутаг дахь хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор Багийн эмч нарыг автомашинаар | | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх | Иргэний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна. | Аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгаврын хүрээнд анхан шатны 15 сум, 6 тосгон, 3 өрхийн эрүүл мэндийн байгууллага алслагдсан малчин өрх болон түр оршин суугаа нийт 2221 иргэнд дотор, мэдрэл, хүүхэд, шүд, эхо, мэс засал гэсэн 6 төрлийн эмчийн үзлэг, элэгний B,C болон бусад түргэвчилсэн шинжилгээ болон явуулын эмийн сан зэрэг тусламж |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хханган, шатахууны зардлыг шийдвэрлэнэ. | | | | үйлчилгээг үзүүлж ажилласан. **Биелэлт 100%** |
| | 3.11.3 | Бүх сумдад анхан шатны тусламж, үйлчилгээний мобайл технологийг нэвтрүүлнэ. | **Улсын төсөв** | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх | Иргэний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна. | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж чаддаггүй алслагдсан, хөдөлгөөнт ба эмзэг бүлгийн хүн амд анхан шатны тусламж үйлчилгээг мобайл технологийг ашиглан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг оношилгоог хийх зорилгоор анх 2017 онд Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас "Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийг өргөжүүлэх нь" төслийн хүрээнд Зүүнбүрэн сум, Дулаанхан тосгоны эрүүл мэндийн төвд зөөврийн ЭКГ, ЭХО, таблет зэргийг өгч, тусламж үйлчилгээнд нэвтрүүлж эхэлсэн.<br>2021 онд тус төслийн хүрээнд өрх, тосгон, сумын 24 эрүүл мэндийн байгууллагад 296.586.720 төгрөгийн өртөг бүхий "Мобайл технологи" буюу хөдөлгөөнт эрүүл мэндийн технологийг нэвтрүүлж, хүлээлгэн өгсөн. Ингэснээр манай аймгийн бүх анхан шатны эрүүл мэндийн төвүүд нь мобайл технологийг нэвтрүүлэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
